



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/218

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд хамгаалал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 1,473,950 (нэг сая дөрвөн зуун далан гурван мянга есөн зуун тавь) төгрөг, шинээр 3 дугаар цэцэрлэг ашиглалтад орсонтой холбогдуулан 3 ангид 30 метр дэвсгэр худалдан авах зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг, сумын заан цол шинээр авсан Ш.Мөнгөнцоож, Д.Эрдэнэбаяр, С.Содномцэрэн нарыг шагнах шагналын зардалд 780,000 (долоон зуун наян мянга) төгрөг нийт 5,253,950 (таван сая хоёр зуун тавин гурван мянга есөн зуун тавь) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 5,253,950 (таван сая хоёр зуун тавин гурван мянга есөн зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөцөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

